



100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ХҮРТГЭЭ! МЭНДЧИЛГЭЭ



ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 256 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ, ДЭД ХУРАНДАА Н.ГҮРБАДАМ

Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартайгаар батлан хамгаалж, баатарлаг тэмцэл, бадрангуй үйлсээрээ дархалсан домог түүхт 5 дугаар морьт хороо /дивиз/-ны дайчин замналыг эдүгээ цагт түүчээлэн яваа Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн 100 жилийн ойн баяр тохиож байна.

Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн хөгжлийн түүхэн цаг хугацаанд тус анги 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд эх орныхоо зүүн, зүүн өмнөд хил, хязгаарыг Батлан хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлэн, эх орон, төр ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж, баатарлаг, бахдам, түүхэн гавьяаг байгуулж, 1961-1982 онд хөгжил дэвшил, энхийн хөдөлмөрийн талбайд аранзал улаан тугаа намируулан төрт улсынхаа бүтээн байгуулалтын ажилд манлайлан оролцож өнөө цагийн Зэвсэгт хүчний шинэ хөгжил, дэвшилтэй нийцүүлэн ангийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшинг ханган өнөөдрийн он цагийн хэлхээстэй учран золгож байна.

Эх орноо Батлан хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж

ирснийг төр, засгаас өндрөөр үнэлж, "Цэргийн гавьяаны улаан тугийн одон"-гоор шагнасан явдал нь ахмад үеийнхний бүтээсэн алдар гавьяа, залгамж халаа өнөө үеийнхний ололт амжилтыг үнэлж, бидний их үйлсийн урам зоригийг бадраасан юм.

Монгол Улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын удирдлага, эрхэм генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч, хилийн чандад үүргээ нэр төртэй гүйцэтгэж буй энхийг сахиулагчид, эх орноо Батлан хамгаалах үйлсэд хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэндээ анги байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж, ажлын арвин их амжилт, амьдралын аз жаргал, эрүүл энхийг бэлгэдэн ерөөе.

Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь, үеийн үед мандан бадрах болтугай!
МОНГОЛ ЦЭРГИЙН ӨЛМИЙ БАТ ОРШИГ.

ДАЙЧИН ЗАМНАЛЫН ТҮҮХЭН ТОВЧОО

Орчин цагийн Зэвсэгт хүчний үүсэн байгуулагдсан 100 жилийн хугацаанд тус анги нь Бүх Цэргийн зөвлөлийн 1921 оны 8 дугаар сарын 1-ний өдөр гаргасан 10 тоот тушаалаар 2 дугаар морьт бригад Монгол Улсын зүүн хязгаарт байгуулагдсан нь 5 дугаар мотобуудлагын дивизийн анхны суурь болсон.

1959 оноос Буудлагын батальон, 1961 оноос Барилгын цэргийн батальон, 1982 оноос Мотобуудлагын дивиз, 1998 оноос Мотобуудлагын бригад, 2002 оноос Мотобуудлагын тусгай хорооны бүтэц орж байсан бөгөөд 2018 оноос Танкийн тусгай хорооны бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.

1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд тус дивиз нь оролцож анги, салбаруудын хамт байлдааны үүргээ амжилттай биелүүлсэн юм.

Тус ангийн байлдааны аранзал улаан туг 1961-1982 онд энхийн хөдөлмөрийн талбарт 20 гаруй жил намрч, дивизийнхээ дайчин уламжлалыг бүтээн байгуулалтын бахдам амжилтаар баяжуулж, Дархан хотын цагаан тоосгоны

завод, Дархан, Шарын голын төмөр зам, сургуулийн барилга, САА-н барилга, Улаанбаатар хотын Сонгино дахь БиокOMBинатын цогцолбор зэрэг олон арван том барилга, байгууламжийг барьж чанарын өндөр үзүүлэлттэйгээр хүлээлгэн өгсөн юм.

Түүнчлэн БХЯ-ны коллегийн 1982 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 5 дугаар хуралдаанаар 5 дугаар мотобуудлагын дивизийн бүтэц орон тоогоор өргөтгөн зохион байгуулагдаж, байлдааны бэлэн байдал, цэргийн сургалт бэлтгэлийг эрчимтэй явуулж, Ардын Армийн түүхэнд 1987 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс 6 дугаар сарын 4-ний өдрүүдэд "Зоргол-87" дайчилгаатай хээрийн сургуулийг 3 үе шаттайгаар амжилттай зохион байгуулсан түүхтэй.

1987 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн Батлан хамгаалахын сайдын тушаалаар нэгтгэлийг Төв аймгийн Зуунмод хотоос Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын нутаг "Их-Уул" гэдэг газарт шилжүүлэн байрлуулснаас өнөөг хүртэл 34 жилийн түүхэн хугацаанд хуулиар хүлээсэн үндсэн болон тайван цагийн үүргээ нэр төртэйгөөр биелүүлж үйл

ажиллагаагаа явуулж байна.

Тус ангийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 7

дугаар сарын 10-ны өдрийн 139 дүгээр зарлигаар "Цэргийн гавьяаны улаан тугийн одон"-гоор шагнагдсан.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
161.575 +1,231	160.662 +2157	802 +6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
4072 +73	262 +14	3734 +24

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 196,734,297
Эдгэрсэн	Нийт: 178,136,074
Нас барсан	Нийт: 4,203,968

ДЕЛЬТА ХУВИЛБАР АНХЛАРАХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

- Суулгах
- Хамар битүүрх, нус гоожих
- Булчин өвдөх
- Урт хугацаагаар толгой өвдөх
- Бөөлжих
- Хоолой өвдөх
- Бие тавиурх, идэрх

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
16	9
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
30	21
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
35	21

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.849.0	2.851.0
EUR	3.37.5	3.390.0
CNY	439.5	441.0
RUB	38.20	39.40
JPY	25.68	26.22
KRW	2.44	2.53

ЗУРХАЙ

2021.07.30 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 21/

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН ДӨРВӨН НОГООН ШАРГАЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Өвчин ирнэ
Наран ургах, шингэх:
05:26-20:31
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй
Суудал:
Огтойгүй

Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, морь, хонь, тахай, нохой, гахай үхэр, луу, могой, хонь, болой.

Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үе, асуулт болно.

ТҮҮХЭНД ТОДООР БИЧИГДЭН ҮЛДЭХ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- Ардын Армийн түүхэнд улс ардын аж ахуйгаас оногдуулан дансласан бэлтгэл үүргэтэн, техникүүдийг Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар, Төв аймгаас татан авч анги, салбаруудад хуваарилж, 1987 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс 6 дугаар сарын 4-ний өдрүүдэд "Зоргол-87" дайчилгаатай хэргийн сургуулийг Төв аймгаас Дундговь аймгийн заагт Шанхын хөндийд Зоргол хайрхны өвөрт зохион байгуулсан. Тус сургуульд БНМАУ-ын сайд нарын Зөвлөлийн дарга Д.Содном, БХЯ-ны сайд, хурандаа генерал Ж.Ёндон тэргүүтэй удирдах тушаалын генерал, офицерууд оролцож сургуулийн үйл явцыг өндөрөөр үнэлэв.

- 2004, 2006, 2008, 2011, 2015, 2019 онд ЗХЖШ-ын даргын нэрэмжит цогцолбор шалгалтаар "Сайн" дүнтэй шалгагдаж, 2007 онд Зэвсэгт хүчний хэмжээнд зарласан "Сахилгын зөрчилгүй тэргүүний анги" шалгаруулах болзолт уралдаанд тэргүүн байр, 2018



онд Зэвсэгт хүчний "Тэргүүний анги"-аар тус тус шалгарсан амжилтууд үзүүлсэн.

- Зэвсэгт хүчний хэмжээнд явагддаг марш, тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг, салаа шалгаруулах тэмцээнд тогтмол амжилттай оролцож, 1997-1999 онд 3 жил дараалан тэргүүн байрт шалгарч, алтан медаль авч маршийн цомыг үүрд хадгалсны дээр 2001 онд мөнгө, 2002 онд хүрэл, 2005 онд мөнгө, 2007 онд мөнгө, хүрэл, 2009 онд байнгын бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагчдын салаа мөнгө, 2011 онд байнгын бүрэлдэхүүний салаа мөнгө, хугацаат цэргийн алба хаагч хүрэл, 2012 онд гэрээт цэргийн тасаг хүрэл, 2017 онд

гэрээт цэргийн тасаг алтан медалиудыг тус тус авч нийтдээ марш, тактикийн аварга тасаг, салаа шалгаруулах тэмцээнээс 40 гаруй медаль хүртсэн амжилтаар түүхт 100 жилийн ойгоо угтаж байна.

- Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсэн цагаас тус ангиас Ирак, Афганистан, Сьерра-Леон, Чад, БНӨСУ, Баруун Сахар, Конго зэрэг улсад давхардсан тоогоор 1000 гаруй алба хаагч оролцож, үүргээ амжилттай гүйцэтгэсэн. Өнөөдрийн байдлаар 30 гаруй алба хаагч ажиллагааны газар оронд үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

НЭГТГЭЛИЙН ЗАХИРАГЧААР АЖИЛЛАСАН МИНЬ



олон зуун офицер, ахлагч, түрүүч, байлдагч, олон арван техник мөн Барилгын цэргээс олон тооны офицер, ахлагч, түрүүч, байлдагч нар оролцсон. Ерөнхийдөө өргөн зурваст олон зуун цэргийн албан хаагчийг техниктэй нь дэлгэхээд удирдлагаар хангана гэдэг нь тун амаргүй байлаа. Энэхүү "Зоргол-87" хэргийн сургууль нь Зэвсэгт хүчний цаашдын хөгжил, байнгын бэлэн байдлыг дээшлүүлэхэд томоохон хөрөнгө оруулсан өндөр ач холбогдолтой сургууль байсан юм.

Тус сургуулийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Д.Содном, тухайн үеийн нам, төрийн удирдагчид, Батлан хамгаалах яамны сайд хурандаа генерал Ж.Ёндон тэргүүтэй генерал, офицерууд өндөрөөр үнэлж байсан нь саяхан мэт санагдаж байна. Харин "Зоргол-87"-оос сар гаруй хугацааны дараа Батлан хамгаалах яамны сайдын 7 дугаар сарын 14-ний өдрийн тушаалаар 5 дугаар мотобуудлагын дивизийг Төв аймгийн Зуунмодоос Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын "Их-Уул" цэргийн хүрээнд шилжүүлэн байрлуулах шийдвэр гарч 7 дугаар сарын 28-ны өдрөөс гурван цуваа болгон зохион байгуулсан. Нүүж очоод дивизийг байрлуулах, өвөлд бэлтгэх гэсэн том ажилтай нүүр тулсан юм.

Орос цэргийн ангиас үлдсэн 100 гаруй барилга байгууламж объектын хүлээн авч анги, салбаруудад хүлээлгэн өгч засвар тохижилтын ажлыг намаржингаа хийж бэлдсэний хүчинд өвлийг өнөтэй давсан. Түүнчлэн дивиз байрласнаас хойш офицер, ахлагч нарын хүүхдүүдийн сургууль, цэцэрлэг байгуулагдаж, БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн зарлигаар Өвөрхангай аймгийн Их-Уул хороог шинээр байгуулан 2 жил хорооны даргаар ажилласан юм.

Тухайн үед надтай хамт ажиллаж байсан журмын нөхөд штабын дарга, хурандаа С.Баттулга, улс төрийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Жанцан, хошууч Ц.Тогоо, ар талын орлогч, дэд хурандаа Ж.Цэвээндорж, дэд хурандаа Т.Цагаач техникийн орлогч, хурандаа Т.Тогтох нар маань салбарынхаа үйл ажиллагааг сайн удирдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Ингээд 1990 онд Өвөрхангай аймгийн 257 дугаар тойргоос АИХ-ын депутатаар сонгогдон Улсын Бага Хурлын гишүүн болж улс төрийн албанд 2 жил зүтгэн Монгол Улсын үндсэн хуулийг батлалцсан юм.

Дурсамж, дурдатгал, түүх өгүүлэх эдгээр он жилүүдэд надтай хамтран ажиллаж миний ажлыг дэмжиж байсан орлогч нар болон хороо, ангиудын захирагч нар офицер, ахлагч, ажилтан алба хаагч нартаа алдарт түүхтэй нэгтгэлийнхээ 100 жилийн ойн мэндийг дэвшүүлэн талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Мөн тус нэгтгэлтэй ажил амьдралаа холбон түүхийг бүтээлцсэн бүх ахмад үеийнхэндээ болон өнөө үед тэднийг залгамжлан нэр, төр, алдар гавьяаг нь улам баяжуулан авч яваа Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн бие бүрэлдэхүүнд халуун баяр хүргэв.

Чөлөөнд байгаа хошууч генерал Ч. ЦЭРЭНДАГВА

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ



Тус анги нь энэ хугацаанд улс орны энх цагийн бүтээн байгуулалтад оролцож явсан бахархам түүхтэй. Тухайлбал, 1987 онд Өмнөговь, 1988, 1990, 2009, 2010 онд Өвөрхангай, 1993, 1999 онд Баянхонгор, 2000 онд Завхан аймагт болсон байгалийн гамшиг, цас зудтай тэмцэх, 2002 онд Монгол Улсын их бүтээн байгуулалт "Мянганы зам" тавих ажил, Завхан аймгийн "Бөхөн

шарын даваа" зэрэг томоохон давааг засах, 2005 оны 7-8 дугаар сард Өмнөговь аймгийн Мандал овоо, Дундговь аймгийн Сайхан овоо сумдыг холбосон 100 км шилэн кабель тавих, "Шинэ сум" төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянлиг, Бууцагаан сумын барилга, байгууламж, С а й н ш а н д а а с Алтанширээ сумын нутаг хүртэл 17,5 км хүнд даацын автомашины засмал зам, Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцож, Улс орны хөгжил цэцэглэлтэд нэрээ мөнхөлсөн бахархам түүхтэй.

БАХАРХАН ДУРСАХ ОН ЖИЛҮҮД

1990 онд БХЯ-ны сайдын тушаалаар Ардын цэргийн 256 дугаар ангид клубийн даргын албан тушаалд томилогдсон. Томилгодон ирэхэд нэгтгэлийн улс төрийн хэлтсийн дарга, хошууч Ц.Тогоо, клубийн дарга, хошууч Ц.Сүхбаатар нар болон хороо ангиудын улс төрийн орлогч нарын хамт олон сайхан хүлээн авч билээ.

Тус нэгтгэл нь цэргийн болон офицеруудын клуб, соёлын төв, номын сан, алдрын тасалгаа зэрэг соёл хүмүүжлийн ажил явуулах бүх бололцоогоор хангагдсан байсан нь улс төрийн ажилтан бидэнд ихээхэн тус дөхөм болж байв.

Төрийн шагналт, Ардын жүжигчин С.Намдагийн зохиол "Маш нууц" жүжгийг хошууч Ц.Сүхбаатар найруулан тавьж Өвөрхангай аймгийн Хөгжимт драмын театр болон бүх суманд үзүүлж, цэрэг-эх орны сэдэвт концерт, үлээвэр найрал хөгжимтэй үзүүлэх тоглолт, уулзалт өдөрлөг, үдэшлэг зэргийг зохион байгуулсан тухайн үед иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чухал алхмууд болсон юм.

Нэг удаа ангийн захирагч, хурандаа Д.Цэрэндагва улс төрийн орлогч, дэд хурандаа Н.Бумцэнд бид 2-ыг дуудаж анги сүлд дуутай болмоор байна, орлогч шүлгийг нь бич, нөхөр Ж.Отгонбаяр аяыг нь хий гэж үүрэг өгөв. Орлогч 7 хоногийн дотор маш гоё шүлэг бичиж надад үзүүлэв, би тэр дор нь дахилтыг нь жаахан уншиж байгаад мартаж орхив.

Гэтэл нэг өдөр захирагч, хурандаа Д.Цэрэндагва өрөөндөө дуудаж "За хөө жагсаалын дуу хаана байна вэ" гэв. Би тэр үед их сандарч бараг бэлэн болсон гэж хариултал хоёр хоногийн хугацаа өглөө. Би тэр үед аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын их эмч Биндэръяатай хамт компьютер дээр нотлох гэж шөнөжин сууж маргааш өглөө нь "Хөгжимт драмын театр"-ын хөгжмийн багш О.Нармандахтай уулзаж нөгөө нотоо шалгуулснаар "Их-Уул цэргийн хүрээ" дуу төрсөн түүхтэй. Тэр цагаас хойш ангийн маань сүлд дуу өдий хүртэл эгшиглэж байгаад миний бие яамт баярлаж байдаг юм. Ингээд Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний



256 дугаар ангийн нийт бие бүрэлдэхүүндээ түүхт 100 жилийн ойн баярын мэндчилгээ дэвшүүлж эрүүл энх сайн сайхан бүхийг хүсэн ерөөв. Монгол цэргийн мэлмий бат оршиг.

Монгол Улсын СТА, бэлтгэл хошууч Ж.ОТГОНБАЯР

АЛБАА ХААХ ХУГАЦААНД АНГИЙН МААНЬ ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙ ТОХИОЖ БҮЙД ТУЙЛЫН ИХ БАЯРТАЙ БАЙНА



Зэвсэгт хүчний ууган ангийн нэг болох тус хороонд алба хаасан болон мөр зэрэгцэн алба хааж байгаа генерал, офицер, ахлагч, ажилчин албан хаагч, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагч Та бүхэнд ангийн түүхт 100 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөв.

Миний бие Зэвсэгт хүчинд 20 дахь жилдээ алба хааж байна. Анх 2001-2002 онд БХИС-ийн Ахлагчийн сургуулийг артиллерийн тагнуулчин мэргэжлээр төгсөж, тус ангийн артиллерийн удирдах батареинд дуу чимээний баазын даргаар томилогдон ажлынхаа гарааг эхлүүлж байлаа.

Энэ хугацаандаа ангийн хамт олныхоо дэмжлэгээр 2006 онд "Иракийн эрх чөлөө ажиллагаа"-ны 6 дугаар ээлж, 2009 онд Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх артиллерийн сургалтын хөдөлгөөнт багийн 9 дүгээр ээлж, 2016 онд БНӨСУ-ын НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагааны 6 дугаар ээлжид тус тус үүрэг гүйцэтгэсэн.

Зэвсэгт хүчинд алба хаах хугацаанд ангийн маань түүхт 100 жилийн ой тохиож буйд туйлын баяртай байна.

Минимётын батареины ахлагч, сурагч ахлагч Э.ТАЙВАН

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 256 ДУГААР АНГИАС ТӨРСӨН АЛДАРТНУУД

Морьт дивизийн үе үеийн удирдлага бие бүрэлдэхүүнээс олон арван алдартан төрөн гарсан нь бидний бахархал, үлгэр дуурайлал болсоор байна.

МОНГОЛ УЛСЫН БААТАР

- Богд Хааны зарлигаар 1922 онд Монгол Улсын хурц баатар М.Дугаржав
- Армийн генерал Б.Дорж (1952-1953 онд 5 дугаар морьт бригадын дарга)
- Хурандаа генерал Б.Цог (1942-1943 онд 5 дугаар морьт дивизийн их бууны 5 дугаар дивизоны дарга)
- Хурандаа Л.Дандар (1938-1945 онд 5 дугаар морьт дивизийн 13 дугаар морьт хорооны дарга)
- Хурандаа П.Чогдон (барилгын 5 дугаар батальоны дарга)

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР

- Хурандаа Д.Бямбаа (1949-1954 онд 5 дугаар дивизийн морьт хорооны дарга)
- Байлдагч Л.Дамдинсүрэн (1952-1957

онд 5 дугаар морьт бригадд байлдагч)

- Байлдагч Т.Тангад (1945-1946 онд 5 дугаар морьт дивизийн хуягт дивизионд танкийн механик жолооч)

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТУУД

- Ахлагч Д.Галсантогтох Гавьяат жүжигчин (1982-1984 онд дивизийн кино механикч)
- Ахмад С.Батсүх Гавьяат тамирчин (1982-1984 онд биеийн тамир спортын дарга)
- Ахлах дэслэгч О.Шагжаа гавьяат тамирчин (1984-1986 онд биен тамир спортын дарга)
- Байлдагч Т.Цогтбаяр Соёлын гавьяат зүтгэлтэн (шог зураач)
- Хурандаа Н.Мөнхөө Гавьяат барилгачин (барилгын хорооны захирагч)



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)